



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/456

Зуунмод

Газар хамгаалах, нөхөн сэргээх арга
хэмжээгээр эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 56 дугаар зүйлийн 56.4, 56.6, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хур их цугларсан хогийн цэгийг цэвэрлэх, нөхөн сэргээх, хашиж хамгаалах, мод бут, сөөг, загийг шинээр тарих зорилгоор газар эзэмшихээр өргөдөл ирүүлсэн “Уртзам” ХХК (2039672)-д Баяхношуу /3-р/ багийн хогийн цэгт Мод үржүүлгийн зориулалттай 2.4 га (24372м²) газрыг хуулийн дагуу 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч “Уртзам” ХХК (2039672)-д дараах үүргийг хариуцуулсугай.

2.1.Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2.Газрын кадастрын зураглалыг хийлгэж, Мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3.Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4.Эзэмшиж байгаа газрынхаа эргэн тойронд (50-аас доошгүй метрийн)-ийн доторх хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, орчноо цэвэр ариун байлгах арга хэмжээ авах.

3.Газрын даамал (Г.Баярсайхан)-д дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1.Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2.Газрын төлбөрийг хугацаанд нь төсөвт оруулах.

3.3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

ЗАСАГ ДАРГА

САРАНГЭРЭЛ

